

## ГЭР БҮЛ БА НИЙГМИЙН АСУУДЛУУД

**Д.Нарантуяа,**

Докторант, ШУТИС-ийн Хүмүүнлэгийн ухааны сургууль,  
Нийгмийн халамж зүйн тэнхимийн багш

*Хөгжлийн ойлголтод хүмүүсийн өөрийгөө үнэлэх үнэлгээ, амьдралын идэвх, итгэлийг дээшлүүлэх тийм нийгэм, эдийн засаг, улс төрийн системийг бүрдүүлэх асуудал багтдаг. Харин хувь хүн өөрийн итгэл, идэвхтэй амьдралынхаа эх сурвалжийг анх гэр бүлээсээ олдог.*

*Энэхүү ажилд, Гэр бүл бүрэн бус бүтэцтэй, бие биеэ тусалж дэмжих зэрэг анхдагч гэр бүлийнхээ үүргийг гүйцэтгэж чадаагүй үед хүмүүсийн эрүүл мэнд, амьдрал байдлыг сайжруулах зорилгыг гүйцэтгэхэд бэрхшээлтэй болдог талаар хувь судлаачийн ажиглалт, судалгаа, дүгнэлтийг бодит жишээ баримттайгаар өгүүлсэн болно. Уншигч та энэ ажлаас гэрлэлт, гэр бүл, түүний үүрэг юу болох, гэр бүлийн үүргийг умартсанаас учрах бэрхшээл, түүнийг даван туулах зарим арга замын талаарх судлаачийн үзэл бодол, зөвлөмжтэй танилцах боломжтой юм.*

**Гэрлэлт** гэж эр, эм хоёр дэр ба хөрөнгөө нэгтгэснийг нийгмээр хүлээн зөвшөөрснийг хэлнэ. Гэрлэсэн хоёр хөрөнгө санхүү, хүүхэд өсгөх гэх мэт асуудалд эрх үүргээ харилцан хүлээлцдэг.

Гэхдээ дэр ба хөрөнгөө нэгтгэсэн эр, эм хоёрыг л гэрлэсэн хосууд гэж үздэг үзэл түүхийн бүхий л үеийн туршид нэг хэвээр байгаагүй байна. Жишээ нь, 19-р зуунд Энэтхэгийн өмнөд хэсэгт оршин суудаг Наяарууд охидоо нас бие гүйцмэгц нөхөрт гаргадаг байв. Эрэгтэй нь хүүхнийхээ хүзүүнд алтан чимэглэл зүүж өгснөөр тэд эхнэр нөхөр болдог боловч түүнээс хойш нөхөр болох хүн нь эхнэрийн өмнө ямар ч үүрэг хариуцлага хүлээдэггүй бараг дахиж уулздаг ч үгүй байна. Наяар залуучууд хөлсний цэрэг болж хаа нэгтээ одох бөгөөд өөрийн гэрийнхэнтэйгээ үлдсэн эхнэр болох хүн нь ирсэн зочид болон байнга ирдэг хүмүүстэй бэлгийн харьцаанд орж хүүхэдтэй болдог. Байнга ирдэг залуус эмэгтэйд даавуу, самар зэрэг бэлэг өгөх боловч хүүхнийг болон хүүхдийг тэжээх үүрэг хүлээхгүй. Өөрөөр хэлбэл, дэрээ ч хөрөнгөө ч нийлүүлээгүй боловч дээрхийг Наяарууд гэрлэлт хэмээн тооцдог байв.

Үүнээс гадна зөвхөн эсрэг хүйсний биш, мөн ижил хүйсний хүмүүс гэр бүл болохыг зарим газар хүлээн зөвшөөрдөг. Энэтхэгийн чиеннэ болон Африкийн зарим нутагт ижил хүйсийн хүмүүс суухыг зөвшөөрдөг байжээ. Хоёр эмэгтэй гэр бүл болохыг зөвшөөрдөг Африкийн нэгэн нутагт "нөхөр" болох эмэгтэй нь "эхнэртэй" хүүхэд гаргах эрэгтэйг олж өгдөг байна. Харин "эхнэр", "нөхөр" болсон эмэгтэйчүүд бэлгийн харьцаанд ордог эсэх нь тодорхойгүй ажээ. Суданы нутаг Английн колони болохоос өмнө эхнэр авах бэл муутай Африкийн Азандечүүд залуу хөвүүдийг эх эцэгт нь их биш бэлэг барьж "эхнэр" болгон авдаг байсан байна. Тэд бэлгийн харьцаанд орохоос гадна эхнэр болсон хөвүүн өрх гэрт хүлээх эмэгтэй хүний ихэнх үүргийг гүйцэтгэдэг байжээ.

**Гэрлэлтийн хэлбэрүүд:** Гэрлэлт янз бүрийн хэлбэртэй байдаг. Нэг эрэгтэй нэг эмэгтэйтэй гэр бүл болсон бол **моногам**, нэг дор олон эхнэр авсан бол **полижен** гэж нэрлэдэг байна. Нэг эмэгтэй нэг дор нэгээс дээш тооны нөхөртэй гэрлэсэн бол **полиандри** гэж нэрлэдэг бөгөөд полижен ба полиандриг полигам гэж ерөнхийлөн нэрийддэг. Харин нэг дор хоёр ба түүнээс дээш эрэгтэй хоёр ба түүнээс дээш тооны эмэгтэйтэйтэй гэрлэснийг **бүлэг гэрлэлт** гэнэ.

**Гэр бүл** гэж ихэвчлэн нэг тооно дор амьдрах эцэг эх, хүүхэд гэж бид ойлгодог. Гэр бүл болсон эр, эм мөн эх эцэг болон хүүхдүүд эрх үүргээ харилцан хүлээсэн байдаг.

Гэрлэлтийн дээрх хэлбэрүүдээс гадна гэрээгээр гэрлэх буюу тодорхой хугацаанд гэр бүл болж байгаад хоёр тийшээ болох, нээлттэй гэрлэлт буюу гэр бүлээсээ гадуур бэлгийн харьцаанд чөлөөтэй орж болдог хэлбэрүүд бий. Харин 1970-аад оноос АНУ болон хөгжингүй орнуудад хамтран амьдрах хэлбэр нэлээд дэлгэрэх хандлагатай болсон байна. Зарим нэг судалгаанаас харахад, хамтран амьдарч байгаад гэрлэсэн хосуудын дунд салах тохиолдол илүүтэй байдаг ажээ. Америкийн гэрлэсэн хосуудын дунд хийсэн судалгаанаас үзэхэд, гэрлэхээсээ өмнө хамтран амьдарч байсан хосуудын 53 хувь нь, ийм хэлбэрээр амьдарч байгаагүй хосуудын 28 хувь нь 10 жилийн дараа салцгаасан байна / 5: 455/.

Манай орны хувьд сүүлийн арваад жил салалтын үзүүлэлт онц өөрчлөгдөөгүй байна. Харин 2000 оны байдлаар 1000 хүн дутамд 9 гэрлэлт ногдож байгаа нь 1990 оныхоос 1,9 пунктээр бага байгаа юм /1/ .

Олон оронд гэрлэх нас хойшилж, гэрлээгүй залуусын хувийн жин болон ерөөсгөл гэр бүлийн тоо нэмэгдэж, хамтран амьдрах хэлбэр дэлгэрч, гэр бүлийн салалт ихэсч байгаа нь гэр бүл бидний ойлгодог тэр утгаар оршсоор байх эсэх тухай асуудлыг зүй ёсоор хөндөж байна.

*Гэр бүлийн үүрэг.* Гэр бүл, бэлгийн зохистой харьцааг хадгалах, хүүхэд төрүүлж өсгөх, боловсрол , шашин шүтлэг олгох, итгэл үнэмшлийг бий болгох, чөлөөт цагаа өнгөрөөх, амьдралын янз бүрийн хэрэгцээгээ гүйцэлдүүлэх зэрэг олон янзын үүрэгтэй байдаг. Энэ үүргийн заримыг сургууль, сүм хийд, үзвэр үйлчилгээ, амралтын зэрэг газар гүйцэтгэх болов. Харин бэлгийн зохистой харьцааг хадгалах, хүүхэд төрүүлж өсгөх үүрэг нь харьцангуй тогтвортой хадгалагдан үлдсэн байна.

Үүнээс гадна хувь хүнд **анхдагч бүлийг** бий болгодог үүргийг гэр бүл гүйцэтгэдэг. Энэ бүл нь хувь хүн бүрэлдэхэд чухал нөлөө үзүүлдэг. Гэр бүлийн талаарх нэртэй судалгааны талаар А. Фрейд болон Д.Бурлейнхам нар өгүүлсэн нь бий. Хүүхдийн асрах газарт хүмүүжиж буй хүүхдүүдийн хөгжил дуталтай байсныг ажигласны үндсэн дээр дуураймал "гэр бүл" зохион судалгаа хийжээ. Асрах газрын ажилтнууд хүүхдүүдийг гомдоож магадгүй гэж бодсоны улмаас хэн нэгэнд нь илүү дотно байгаагаа илэрхийлдэггүй байжээ. Энэ нь хөгжлийн дуталд нөлөөлөөд байж магадгүй мэт санагдсанаар нэг "ээж", 4 хүүхэд бүрээр нэг гэр бүл зохиосон байна. Энэ нь гайхмаар үр дүнд хүргэжээ. Долоо хоногийн дараа тогтвортой 6 гэр бүл бүрэлдсэнээр хүүхдүүдийн хөгжил илт дээшилсэн байна. Цэвэр цэмцгэр байхад яаж ч сургаад нэмэргүй гэж бодож байсан хүүхдүүдэд хүртэл гэнэтийн нааштай өөрчлөлт гарсан байна /5:457/.

Энэ нь хүнд хайр энэрэл, дотно харьцаа хичнээн чухал болохыг харуулсан жишээ юм. Тэр нандин бүхнийг хүн гэр бүлээсээ л анх хүртдэг.

Амьдрал дээр, анхдагч бүлийнхээ үүргийг гүйцэтгэж чадахгүй гэр бүл бэрхшээлтэй тулгардаг.

Гэр бүл үүргээ гүйцэтгэхийн тулд юуны өмнө **бүрэн бүтцээрээ** байх ёстой. Өөрөөр хэлбэл хүүхэд бүр ээж, аавтайгаа байх ёстой гэсэн үг. Хоёрдугаарт гэр бүлийн гишүүд **бие биеийгээ тулж дэмжих** үүрэгтэй. Ийм биш тохиолдолд хүн амын сайн сайхан амьдралыг хангахад бэрхшээлтэй байдаг.

Монгол улс 2000 оны байдлаар 554000 өрхтэй байгаагаас 56491 нь эмэгтэй тэргүүлэгчтэй өрх байна /1/. Хараа хяналтгүй хүүхдүүдийн 80 хувь нь хагас өнчин бөгөөд хагасаас илүү нь хавчигдаж зовсон хүүхдүүд байна гэсэн тооцоо гарсан байна. Гадны судалгаануудаас үзэхэд, эмэгтэй тэргүүлэгчтэй гэр бүлийн орлого бүтэн гэр бүлийнхтэй ойролцоо байсан ч хүүхдүүд нь гэмт хэрэгт өртөх, сургууль завсардах, хичээлдээ хоцрох, гэрээсээ дайжих, тамхи татах, бэлгийн харьцаанд эрт орох тохиолдол илүүтэй байдаг байна. Ялангуяа хүүхдийг 8-9 насанд эцэг эх нь салсан тохиолдолд тэд бусадтай зохицох чадвар сул, өөрийгөө үнэлэх үнэлэмж багатай, түрэмгийлэх, нийгмийн бусад гаж үйлдэл хийх нь их байдаг нь ажиглагджээ.

Гэр бүлтэй хүмүүсийн эрүүл мэнд гэр бүлгүй хүмүүсийнхээс илүү сайн байдгийг олон судалгааны дүн нотолж байна. Гэр бүлээ зохиогоогүй хүмүүс сэтгэл санааны байдлаас шалтгаалан нас барах тохиолдол гэр бүлтэй хүмүүсийнхээс мэдэгдэхүйц өндөр байдгийг Гав /6: 167-168/ тэмдэглэсэн байдаг. 25-64 насны гэрлээгүй эрчүүдийн дунд амиа хорлох үзэгдэл гэр бүлтэй эрчүүдийнхээс 2 дахин их байдаг байна. Архидалтаас улбаатай элэгний церроз өвчнөөр нас барах явдал гэрлээгүй ба ялангуяа салсан эрчүүлийн дунд түгээмэл байдаг ажээ. Гэр бүлтэй хүмүүс өөрийн санаачилгаар биш гэхэд, гэр бүлийн бусад гишүүдийг шаардлагаар эмчид хандаж, эрүүл мэнддээ анхаарал тавих нь илүүтэй байдаг.

1993-1994 онд Улаанбаатар хотын Эх нялхсын эрдэм шинжилгээний төвд хийсэн судалгааны дүнгээс үзэхэд, хэвлийд бойжих үр, нярай хүүхдийн эрүүл мэндэд эхийн сэтгэл санааны байдал эдийн засгийн хүчин зүйлээс илүүтэй нөлөөлсөн байв. Гэрлэлтээ батлуулсан ээжээс төрсөн хүүхдийн дундаж жин 3125 грамм байхад ганц бие эхчүүдээс төрсөн хүүхдийнх 2570 грамм буюу 555 граммаар дутуу байна. Дөнгөж төрсөн хүүхдийн эрүүл мэндийн үзүүлэлт болох Апгарын оноо мөн гэрлэсэн эмэгтэйчүүдээс төрсөн хүүхдүүдэд хамгийн өндөр байсан юм. Төрсөн хүүхдүүдийн эрүүл мэндийн байдал хүүхдийн цаашдын өсөлт хөгжилтөд нөлөөтэй байдаг.

Эцэг эхтэйгээ байгаа хүүхэд бусад өөр ямар ч гэр бүлд байгаа хүүхдээс илүү нийгмийн, сэтгэл санааны болон материаллаг дэмжлэг хүртдэг. Харин эцэг эх нь салсан юмуу эсвэл байнга зөрчилтэй байдаг айлын хүүхдүүд биеийн болон сэтгэл санааны эмгэгтэй болох нь илүүтэй байдаг юм байна.

**Салалт юунаас шалтгаалдаг вэ?** Гэр бүлийн салалтад олон хүчин зүйл нөлөөлдгөөс хамгийн нийтлэгийг нь дурдвал:

- Хүн амын нөхөн үржихүйн чадавхитай байх хугацаа уртсах тусам салалт ихсэх магадлалтай байдаг байна.

- 20-оос доош насандаа суусан гэр бүлийн салах магадлал түүнээс дээш насандаа гэрлэсэн гэр бүлээс 2 дахин их байдаг.
- Гэрлэхээсээ өмнө жирэмсэн байсан бол салах магадлал мөн 2 дахин их байна.
- Нөхөр нь ажилгүй эсвэл, тогтвортой ажил эрхэлдэггүй, эхнэрийн голдуу орлогоор амьдардаг гэр бүл салах магадлал ихтэй байдаг.
- Салсан гэр бүлийн хүүхэд гэр бүл болоод салах нь мөн илүүтэй байдаг.
- Салах нь "гэм" биш болсон тохиолдолд салалт ихэсдэг.
- Үнэлэмжийн асуудалд ч мөн салахад нөлөөлдгийг зарим судлаачид баталдаг. Тэдний үзэж байгаагаар, гетерогам буюу өөр өөр түвшний хүмүүс сууснаас зохицохгүй салдаг ажээ.

Салахыг голдуу эхнэрүүд л санаачилдаг бөгөөд түүний үндсэн шалтгаанаа хайр сэтгэл хөрснөөр тайлбарладаг. Нөхрүүд ч мөн ижил шалтгаан тоочдог байна. Манай орны хувьд санхүүгийн хүндрэл бэрхшээл салах бас нэг үндсэн хүчин зүйл болдог. Үүний дээр эмэгтэйчүүд нөхрүүд нь тэд нарыг байнга "жижигрүүлдэг" гэж гомдоллодог бөгөөд энэ нь мөн салахад нэрмээс болдог ажээ.

Салалт нь хотжилт, шашин шүтлэг, итгэл үнэмшил болон гэр бүлийн бүтэц өөрчлөгдсөн, нийгмийн интеграци суларсан зэргээс мөн шалтгаалдаг.

**Гэр бүл дэх хүчирхийлэл:** Өнөөгийн монгол гэр бүлд бие биеэ сэтгэл санаагаар дарамтлах явдал нэлээд их байна. Таны бодлоор гэр бүлийн хүчирхийллийн ямар хэлбэр хамгийн их байдаг вэ? гэсэн асуултад оролцсон монголчуудын 61.38 хувь нь сэтгэл зүйн хувьд дарамтлах, 26,8 хувь нь бие махбодид халдаж гэмтээх хэлбэр их байдаг хэмээн хариулжээ /2:67/. Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн мэдээллээр гэр бүлийн хүрээнд хүчирхийлэлд өртөгсдийн 90 гаруй хувийг эмэгтэйчүүд хүүхдүүд эзэлдэг байна. Хүүхдийнхээ эсрэг хүч хэрэглэж байгаа эхчүүдийн ихэнх нь өөртөө итгэлгүй байдаг. Ажилгүй ба бусад шалтгаанаар архинд орсон, сэтгэл санааны хямралтай эрчүүд бухимдлаа гэр бүлийн гишүүддээ гаргаж "тайлах нь" илүүтэй байдаг.

Хүчирхийллийг амссан хүүхдүүд гэр бүл зохиосныхоо дараа гэр бүлийнхнийгээ хүчирхийлэх нь олонтаа. Чамайг хайрладаг хүмүүс чамайг зодож болдог юм байна гэсэн хүүхэд байхдаа авсан ойлголт нь тэднийг ийм байдалд хүргэдэг ажээ.

Хүчирхийлэлд өртсөн хүүхдүүд нийцтэй бус, түрэмгий эсвэл бүр дорой, өөрийгөө үнэлэх үнэлэмж нь доголдолтой байдаг.

Гэр бүлийн хосууд бие биеэ янз бүрээр доош нь хийж муучлах нь салах нэг шалтгаан болдог бол хүүхдээ байнга гоочилж, бусад айлын хүүхдүүдийн сайн, өөрийн хүүхдийн мууг дуудан, хэнд ч хэрэггүй хүн болох мэтээр зэмлэдэг нь хүүхдүүдийг өөртөө итгэлгүй хүнд өшөрхүү болгон өсгөх нэг шалтгаан болдгийг бид тэр бүр ухаардаггүй.

### **Дүгнэлт**

Ажилгүйдэл, ядуурал, архидалт, тэнэмэл хүүхдийн асуудал, хүн амын эрүүл мэндийг сайжруулах, нас баралтыг бууруулах, хүнээ хөгжүүлэх, улмаар улс

орон хүчирхэг байх эсэх нь иргэдийн өөртөө итгэх, идэвхтэй ажиллаж амьдрахаас шалтгаална.

Иймд нийгмийн аливаа асуудлыг авч үзэхдээ хувь хүнийг бүрдүүлж буй гэр бүлийн уур амьсгалыг сайжруулах талаар анхаарч, гэр бүл хосуудад бэрхшээлтэй асуудлыг нааштай шийдэхэд тусалж, ганц бие жирэмсэн эхчүүд, сэтгэл санааны хямралд орсон залуус, сэтгэлийн дэм хайсан хэн бүхэнд туслах талаар илүү анхаарах цаг болсон мэт санагдана. Энэ зорилгоор мэргэжлийн хүмүүс бэлдэж, сэтгэл зүйн зөвлөлгөө өгөх төв ажиллуулах нь чухал шаардлагатай болоод байна. Хүмүүсийг бие биеэ хүндэтгэж, өөртөө итгэлтэй, идэвхтэй болгож сургахад гэр бүл, сургууль хэвлэл мэдээллийн албад хүч бололцоогоо дайчлан ажиллах нь чухал юм.

### Ном зүй:

---

1. Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын тухай илтгэл: Хүний хувийн эрх, эрх чөлөөний төлөв байдал. *Өдрийн сонин* 2002-10-12. № 249
2. О. Мөнхбат, Ц.Болд. Гэр бүлийн харилцааны зарим асуудалд. *Социологи*. 2001 оны дугаар 1. хх. 56-75
3. Д.Нарантуяа. 1994. Нийгэм хүн ам зүйн зарим хүчин зүйлс жирэмслэлтийн төгсгөл ба неонаталь үзүүлэлтэд нөлөөлөх нь. МА тезис. Бээжингийн их сургууль.
4. Ember V. R, & M. Ember. 1990. Anthropology. New Jersey: Prentice Hall. Pp. 325-346
5. Lauer R. H, 1998. Social Problems and the Quality of Life. Boston: WCB, McGraw-Hill
6. Weeks J.R 1989. Population. 4<sup>th</sup> ed. California: Wadsworth Publishing company.